

Түүх 3: Давид ба Ионатан

Библийн эшлэл
[1Самуел 20:4]

Ионатан, Давидад —Хэлсэн бүх санааг чинь чиний төлөө би гүйцэлдүүлье гэв.

Голиаттай тулалдаж түүнийг ялсан Давид Саул хааны ордонд амьдрах болжээ.

Саул хаан Ионатан гэдэг хүүтэй байв.

Эрэлхэг зоригтой Давидад Ионатан маш их сайн байв.

Ионатан болон Давид хоёр үүлзмагцаа маш сайн найзууд болов.

Ионатан өөрийнхөө хамгийн өмсөж дуртай ханхүүгийн дээл болон сэлэм, нум, сүм бүсийг найз Давиддаа бэлэг болгон өгчээ.

Ийнхүү Ионатан Давид хоёр үргэлж нэгнийхээ сайн найз байна гэж тангарга өгрөжээ.

Тэр хоёр бие биедээ туслан, халамжилж сайхан нөхөрлөл дунд өсөж байлаа.

Нэгэн өдөр Саул хаан Давидын хамт дайнаас буцах үед гудамжинд ард түмэн дуулж байхыг сонсчээ.

“Саул хаан мянган дайсныг, Давид түмэн дайсныг хөнөөв.”

Саул хаан маш ихээр уурлажээ.

Учир нь Давидыг ард түмэн илүү ихээр хүндэлж байгааг хараад Саул хааны уур нь хүрсэн аж. Тэрээр бүр илүүгээр Давидыг үзэн ядаж эхэлжээ.

Саул хаан Давидыг хөнөөхийг хүсэв.

Үүнийг мэдсэн Ионатан Давидад их санаа зовжээ.

Тэгээд аавдаа зориглон хэлэв.

“Аав аа, яагаад миний найзыг алахыг хүснэ вэ? Давид Голиаттай тулалдаж ялсан шүү дээ. Тэр маш зоригтой, бас итгэмжтэй хүн шүү дээ.”

Хүүгийнхээ үгийг сонссон Саул хаан ихэд ичив. Тэгээд хүүдээ амлав.

“Тийм ээ чиний үг зөв. Би түүнийг хөнөөхгүй.”





Гэтэл нэгэн өдөр Давидыг ятга тоглож байх үед нь Саул хаан түүн рүү жад шиджээ.

Тиймээс Давид шөнө дунд зугтав.

Түүний зугтсаныг Саул хаан мэдчихэв.

Саул хаан өөрийн хүү Ионатан нь Давидыг зугтахад нь тусалсаныг мэдээд бүр ч их уурлажээ.

Саул хаан аймшигтай ихээр уурлажээ.

Тэгээд Саул хаан Давидын хойноос туслахуудаа явуулав.

Саул хаан Давидыг хөнөөх гэхэд нь Ионатан найзыгаа нэгэн хадны ард нуув.

Саул хаан Давидыг үзэн ядаж хөнөөх гэж оролдож байсан ч Давид Ионатан хоёрын нөхөрлөл бат бэх байлаа.

Ионатан Давидтай нүүцаар үүлздаг байв. Тэгээд Давидад хандан ингэж хэлэв.

“Давид аа, хурдан зугт. Аав чамайг үнэхээр алах гэж байна.” гэж хэлээд тэр хоёр бие биенээ тэврэн үйлцгаав.

Тэдний салах цаг болж Давид зугтжээ. Гэсэн хэдий ч тэр хоёр сайн найзууд хэвээр байлаа.



Үйл ажиллагаа 1.

Давидад өгсөн Ионатаны бэлгийг хайчилж аваад Давидад өмсүүлээрэй.

Хэрэглэгдэх материал: Хайц, цавуу



Жишээ зураг





а. Давид Голиатыг ялсаны дараа хаана амьдарсан бэ?

б. Саул хааны хүүгийн нэр хэн бэ?

в. Ионатан Давидад юу бэлэглэсэн бэ?

д. Өнөөдрийн сурсан түүхээс Давид болон Ионатан хоёр бидэнд юуг зааж өгч байна вэ?

● Дараах эшлэлийг уншаад, цээжлээрэй. (1Самуел 20:4)

Ионатан, Давидад —Хэлсэн бүх санааг чинь чиний төлөө би гүйцэлдүүлье гэв.

